



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/1452

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжих тухай” 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн өмчит “Тавантолгой түлш” ХХК-ийн нийслэлийн өмчид шилжүүлэх хөрөнгийг зохих журмын дагуу хүлээлцэх, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэлийн өмчид зохих журмын дагуу шилжүүлэх саналыг боловсруулан танилцуулахыг Ажлын хэсэг (А.Амартүвшин)-т даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Х. НИЯМБААТАР



1110206661

Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
..... дүгээр сарын .....-ны өдрийн  
..... захирамжийн  
хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	А.Амартүвшин	Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Д.Амгалан	Нийслэлийн Засаг даргын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга
	Б.Энхжин	Нийслэлийн Засаг даргын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
	Ч.Баттулга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Бодлого төлөвлөлт, харьяа байгууллагын үйл ажиллагаа, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Б.Марс-Од	Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Д.Мөнхбаатар	Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга
	В.Оюумаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ц.Даваацэрэн	Тавантолгой түлш ХХК-ийн Гүйцэтгэх захирал
	А.Батзориг	Тавантолгой түлш ХХК-ийн Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга
	Ц.Алтансүх	Тавантолгой түлш ХХК-ийн Ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга:	С.Сарантуяа	Тавантолгой түлш ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч